

Мэдээллийг хүлээн авах

Хүн мэдээллийг хэрхэн хүлээн авдаг вэ?

Дараах мэдээлэл үнэн, зөв эсэх талаар тунгаан бодно уу.

- Хүн чихээрээ дуу чимээ, яриа, шуугиан зэрэг мэдээллийг хүлээн авдаг.
- Хүрээлэн буй орчныхоо үнэрийн талаарх мэдээллийг хамраараа хүлээн авдаг.
- Тухайн зүйл нь давсархаг, чихэрлэг зэрэг ямар амттай байгаа мэдээллийг хэлнийхээ тусламжтайгаар хүлээн авдаг.
- Хүн нүдээрээ өнгийг ялган бичвэр, тоон, график мэдээллийг хүлээн авдаг.
- Хүн нүдээрээ өнгийг ялган бичвэр, тоон, график мэдээллийг хүлээн авдаг.
- Гарын хуруу, биеийн арьсаар шүргэх, хүрэх, тэмтрэх замаар тухайн зүйлийн халуун эсвэл хүйтэн, биетийн гадаргуу толигор эсвэл арзгар талаарх мэдээллийг хүлээн авдаг.

Хүнд мэдээллийг хүлээн авах мэдрэхүйн таван эрхтэн (нүд, чих, хамар, хэл, арьс)байдаг. Уг мэдрэхүйг “харах”, “сонсох”, “үнэрлэх”, “амтлах”, “тэмтрэх” гэж нэрлэдэг.



а) харах



б) үнэрлэх



в) амтлах



г) сонсох



д) тэмтрэх

- Хүн мэдээллийг төрөл бүрийн эх үүсвэрээс хүлээн авдаг. Олон зууны туршид мэдээллийг хүлээн авах үйл явцыг хялбарчлах үүднээс төрөл бүрийн төхөөрөмжүүдийг бүтээсээр иржээ.

